

**Удирдах ажилтнуудын 12 дугаар сарын 20-ний өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2022 оны 01 дүгээр сарын 03

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хэрэгжил тийн хувь
1.	Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн жилийн эцсийн тайланг ирүүлэх	2021.12.24-ний өдрийн дотор	Сумдын Засаг дарга нар, Бүх байгууллагын дарга нарт	Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн жилийн эцсийн тайланг нийт 34 байгууллага Төрийн захиргааны удирдлагын хэлтэст заасан хугацаанд хүргүүлсэн боловч үүргийн даалгаврын биелэлт ирүүлсэн 24 байгууллага байна. Үүрэг даалгаврын биелэлт ирүүлээгүй 10 байгууллага байна. Үүнд: Баянтал сумын Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Сум дундын ойн анги ОНӨҮГазар, Цөм сүрэг ОНӨҮГазар, Биеийн тамир, спортын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Политехник коллеж, Боржигин чуулга, Нэгдсэн эмнэлэг	100
2.	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл зохион байгуулагдах тул хариуцсан байгууллагууд анхаарч ажиллах	2021.12.15-2022.01.20	Сумын Засаг дарга нар, Байгаль орчин, аялал, жуулчлалын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого 2022 оны 01 дүгээр сарын 20-нд нэгдсэн мэдээлэл гарч дуусна. Ажлын явц: Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн маягт хүснэгтийн дагуу төвийн 3 багийн 655 өрхөд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг хийж нэгтгэж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газар агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг 3 сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж байна. Ус цаг уур, орчны шинжилгээний төв аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн гишүүдэд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын маягтуудыг гаргаж хавсралтаар хүргүүлэн чиглэл өгч ажиллаж байна.	42.8
Биелэлтийн дундаж хувь					71.4

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС